Эдийн засаг

# АНУ-ЫН ТӨСВИЙН БОДЛОГО ЭДИЙН ЗАСАГТ

Д.Батсайхан

АНУ-ыг өнөөдөр зах зээлийн сонгодог эдийн засагт гэдгийг хэн ч хүлээн зөвшөөрөх буй за. Хэдийгээр одоо бага болсон боловч дэлхийн хоёр дайны хооронд дэлхийн эдийн засгийн нийт бүтээгдэхүүний 40 орчим хувийг нийлүүлж байсан, дотоод гадаад эдийн засгийн асар их нөөцтэй эдийн засаг, улс төр, соёл иргэншлийн их гүрэн болсон энэ улсын дотоод эдийн засгийн бодлогод төр, засгийн газраас үйлчилдэг механизм буюу төрийн зохицуулалтын нэг гол хөшүүрэг бол засгийн газрын төсвийн бодлого юм. Засгийн газрын төсвийн бодлогыг хэрэгжүүлдэг байгууллагууд нь санхүүгийн хөрөнгийн хөдөлгөөн орлогын хуваарилалт зэрэгт шууд нөлөөлөх үйл ажиллагаа явуулсны үндсэн дээр үндэсний эдийн засгийн гол гол бэрхшээлүүдийг хархэн давснаас АНУ-ын төсвийн бодлогын амжилт, ач холбогдол нь шууд хамаардаг билээ. АНУ-ын албан ёсны эдийн засгийн бодлогын үндсэнд Кейнсийн онолын үндэслэлүүд саяхан болтол тавигдаж байсныг манай эдийн засагчид хэдийнээ мэдэх буй за хэмээхийн зэрэгцээ Кейнсийн онолоор татвар, улсын зардлууд эдийн засгийн субъектүүдийн орлогод шууд нөлөөлж үүгээр дамжуулан харьцангуй үнийн төвшинд нөлөөлдөг ажээ. Татвар нь эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж орлого, татварын ногдлын хуваарилалтын үүднээс ойлгогддог. Мөн төсвийн зохицуулалтын гол хөшүүрэг нь улсын зардал хэмээн авч үздэг. Татварын бодлого нь татагдаж буй татваруудын өөрчлөлт, улсын зардлаас шууд хамааралтай явагддаг. Иймээс энэхүү татварын бодлогын гол үзүүлэлт нь төсвийн өөрчлөлт буюу төслийн илүүдэл ба дутагдал болдог ажээ.

Ийнхүү АНУ-ын улсын төсвийн санхүүгийн үйл ажиллагаа нь түүнийг нийгмийн нөхөн үйлдвэрлэлд макро эдийн засгийн нэгэн үзүүлэлт болоход хүргэжээ. Америкийн улсын төсвийн орлого зарлагын үйл ажиллагаа нь мөнгөн капиталын үйлдвэрлэлийн хэлбэрээ олох явдлыг дийлэнхдээ тодорхойлж бүхэл эдийн засагт санхүүгийн хөрөнгийн урсгалыг тодорхойлогч хүчирхэг хөшүүрэг болдог. Улсын төсөв нь энэхүү санхүүгийн хөрөнгийн хөдөлгөөнд мөнгө, зээлийн хөшүүрэг, түүнийг хэрэгжүүлэгч төв банкны аппаратуудаар дамжуулан нөлөөлдөг.

80-аад оны туршид засгийн газрын төсвийн зардал нь ҮНБ (Үндэсний нийт бүтээгдэхүүн)-ий 23 хувийг тогтмол барьж байсан бол татварын орлого

нь мөнхүү ҮНБ-ий 19 хувийг эзэлж байжээ. Иймхүү төсвийн дутагдал нь 4 хувь орчим хувийг эзэлж байсан ба засгийн газар, муж, орон нутгийн захиргаадын нийт төсөв нь ҮНБ-ий 37 хувьд хүрч байжээ. Энд тодотгоход улсын төсвийн ҮНБ-д эзлэх хувь нь чухал биш, харин энэхүү төсвийн улсын нийт эдийн засгийн санхүүгийн эргэлтэнд гүйцэтгэж буй үүрэг нөлөө нь онцгой юм. Улсын төсөв нь үндэсний эдийн засгийн санхүүгийн системийн са..шгүй нэг хэсэг болсноороо мөнхүү санхүүгийн салбарт төрийн зохицуулалтын механизм нь хувийн се ктортой уялдуулан зохицуулах үүргээ гүйцэтгэж байдагт оршино.

Төрийн зохицуулалтын төсвийн механизм нь хэдийгээр үйлдвэрлэлийг өөгшүүлж, санхүүгийн хөрөнгийн хөдөлгөөнд зохицуулах үүрэг гүйцэтгэж нөгөө талаас нийгмийн хангамж, баялаг хуваарилалтыг аль болох шударгаар гүйцэтгэдэг боловч төсвийн алдагдал, үүнээс үүдсэн засгийн газрын өр гэдэг сөрөг үр дагавар зайлшгүй гарч ирдэг. Энэ сөрөг үр дагаврыг засгийн газраас циклийн өсөлтийн үед татварын төвшинг ихэсгэх замаар даваг байна. Гэвч ийм үр дүнд хүрэх нь ихээхэн хүнд давааны нэг бөгөөд төсвийн алдагдалтай бодлогын уршиг л гэхэд зөвхөн 1981-1987 онуудад улсын төсвийн алдагдал 906 тэрбум доллараас 2,3 трлн долларт хүрчээ. Баяр ёслол, амралтын өдрүүдийг хасаад АНУ-ын Сангийн яаманд өдөр бүр улсын төсвийн алдагдлыг нөхөж улсын өрийг зохицуулах зорилгоор зээлийн хөрөнгийн зах зээлээс 500 сая долларын зээллэг хийгддэг ажээ. Хэдийгээр төсвийн алдагдал нь богино хугацаанд нийт хэрэглээний өсө/т ийн замаар эдийн засгийн өсөлтөнд хүргэдэг боловч удаан хугацааны алдагдал нь сөрөг үр дагавар ихтэй. Америкийн эдийн засагч Р.Холлерийн тооцоолсноор 80-аад оны туршид жил бүрийн засгийн газрын төсвийн алдагдал америкийн хүн амд ногдуулснаар дунджаар 1 мянга орчим болсон ба алдагдлыг нөхөхийн тулд америкийн гэр бүл бүрээс жилд нэмэгдэл 4 мянган долларын татвар авах шаардлагатай болсон байна. Энэ бүхнээс үзвэл төсвийн алдагдлыг нөхөх нь томоохон бэрхшээлийн нэг хэсэг болох нь илэрхий ба энд нэг чухал хүчин зүйл болох улсын төсөвт цэрэг дайны буюу батлан хамгаалахын зардал ихээхэн хувийг эзэлдгийг мартаж болохгүй. Иймээс ч Рейганы засгийн газар "рейганомика" бодлогодоо ард түмний, ялангуяа нийгмийн дунд давхрааныхны ихээхэн талархлыг хүлээсэн татварын дунд, дээд хувийг багасгаж улсын төсвийн алдагдлыг хорогдуулах зорилго тавьсан боловч олигтой амжилтанд хүрээгүй, Бушийн засгийн газар улсын өрийг ихэсгэж "Персийн булангийн дайныг" хийж америкчуудын эх оронч сэтгэлийг сэргээсэн боловч дотоод эдийн засгийн бэрхшээлүүдийг давж чадаагүй билээ. Харин саяхны Ж.Буш, Б.Ельцин нарын гарын үсэг зурсан зэвсэг эрс хорогдуулах хэлэлцээрийн дүнд америкийн эдийн засагт олон жилийн туршид уршиг болж байсан төсвийн алдагдал, улсын өрийг зохицуулах талаар ахицтай үр дүн гарах буй за.

АНУ-ын эдийн з сгийн бодлогын нэг хэсэг үндсэн хэсгийг татварын бодлого эзэлдэг. Аливаа шинэ эдийн засгийн бодлого тунхаглагдах бүр татварын бодлогын шинэчлэл хийгддэг. Учир нь корпорацын ашгийн татвар,

капиталын хөрөнгийн худалдааны татвар зэрэг үйлдвэрлэлд зориулагдаж буй капиталын хэмжээ, бүтцэд шууд нөлөөг үзүүлдэг. Улсаас үйлдвэрлэлд үзүүлж буй нөлөө энэ тохиолдолд маш тодорхой харагддаг. Ийм ч учраас татварын зохицуулалт, татварын хуулинд олны анхаарал үргэлж чиглэгдэж байдаг. Зөвхөн тавхан жилийн дотор жишээлэхэд, АНУ-д татварын хоёр удаагийн шинэчлэл явагдсан байна.

Нэгдүгээрх нь, 1981, 1982 онуудад хувийн орлогын татварын дээд хэмжээ 70-аас 50 хувь хүртэл буурснаар нийт орлогын татвар дөрөвний нэгээр хорогджээ.

Хоёрдугаар нь буюу 1986 оны татварын шинэчлэл нь төсвийн бодлогын чухал үйл явдал болж, өмнөх жилүүдэд байсан орлогын өсөх татварыг бууруулах хандлага агуулжээ. 50 хувийн дээд хувьтай 14 үечлэлтэй татварын оронд 15, 28, 33 хувийн дээд хувьтай гураахан үечлэл тогтоожээ. Татвар ноогдлуулах доод орлогын хэмжээ 2 мянган долларт хүрчээ.

Корпорацуудын хувьд татварын бодлого эрс өөрчлөлтөнд хүрч төсвийн орлогод корпорацийн ашгийн татварын эзлэх хувь ерөнхийдөө 9 хувиас бага болж (1985 онд 8,4 хувь) нийт хөрөнгө оруулалт ихсэхэд нөлөөлж чадсан.

1986 оны татварын шинэчлэлийн нийт үр дүнд өмнөх жилийнхтэйгээ харьцуулбал санхүүгийн 1987 онд улсын төсвийн орлого 11 тэрбум доллараар өсчээ.

Төсвийн алдагдлын хувьд бол энэ нь жил бүр 150-200 тэрбум долларын хэмжээнд байх ахул эдийн засагт дараах чиглэлийн сөрөг нөлөө үзүүлнэ. Нэгдүгээрт, алдагдлыг нөхөхийн тулд Сангийн яам ахин дахин зээл авснаар засгийн дотоод өрийг улам нэмэгдүүлнэ. Хоёрдугаар, мөнгөний зах дээрээс хувийн секторын зээл авах боломж багаснӑас нийт эдийн засгийн хөрөнгө оруулалт буурах нь мэдээж. Эцэст нь, мөнгөний зах дээр засгийн зээл ихсэнээс болж дотоодын санхүү, зээлийн механизмд нөлөөлөн, улмаар АНУ-ын санхүү, зээлийн гадаад харилцаанд өөрчлөлт оруулна. Үүнээс болж мөнгөний ханш бууралт, валютын курс,төсвийн эргэлтэнд өөрчлөлт бий болгох талтай.

# АНУ-ЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН 200 ТОМ КОРПОРАЦИ

| [illegible] | Компани, үндсэн байршил (хот, муж) | Оны [illegible] (сая доллар) 1987 | Актив, сая доллар 1987 | Үндсэн бүтээгдэхүүн ба үйл ажиллагааны салбар |
|---|---|---|---|---|
| 1. | 2. | 3. | 4. | 5. |
| | 1."Дженерал Моторс" (Детройт,Мичиган) | 101781 | 87421 | Автомашин,электрон техник, пуужин |
| | 2."Экссон" (Нью-Йорк,Нью-Йорк) | 76416 | 74042 | Нефть, хий нефтийн бүтээгдэхүүн |
| | 3."Форд мотор" (Диборн,Мичиган) | 71643 | 44955 | Автомашин, пуужин |
| | 4.Интернэшнл бизнес машин" (ИБМ) (Армонк,Нью-Йорк) | 54217 | 63688 | Компьютер, конторын тоног төхөөрөмж |
| | 5. "Мобил" (Нью-Йорк,Нью-Йорк) | 51223 | 41140 | Нефть, хий, нефтийн бүтээгдэхүүн |
| | 6. "Дженерал электрик" (Ферфилд,Коннектикут) | 39315 | 38920 | Электрон техник, нисэх онгоцны хөдөлгүүр, холбооны хиймэл дагуулууд,цахилгаан тоног төхөөрөмж, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл |
| | 7."Тексако" (Уайт-Плейс,Нью-Йорк) | 34372 | 33962 | Нефть, хий, нефтийн бүтээгдэхүүн |
| | 8.Америкен телефон энд телеграф (АТТ) (Нью-Йорк, Нью-Йорк) | 33598 | 38426 | Холбооны электрон хэрэгсэл |
| | 9."Дюпон де Немур" (Уилмингтон,Делевэр) | 30468 | 28209 | Химийн бүтээгдэхүүн |

| | | | |
|---|---|---|---|
| 10."Крайслер" (Хайленд-Парк,Мичиган) | 26257 | 19844 | Автомашин |
| 11."Шеврон" (Сан-Франциско,Калифорни) | 26015 | 34465 | Нефть,хий, нефтийн бүтээгдэхүүн |
| 12 "Филип моррис" (Нью-Йорк, Нью-Йорк) | 22272 | 19145 | Тамхи, хүнсний бүтээгдэхүүн, ундаа, шар айраг |
| 13."Шелл ойл" (Хьюстон,Техас) | 20852 | 26037 | Нефть,хий,нефтийн бүтээгдэхүүн |
| 14."Амоко" (Чикаго,Иллинойс) | 20174 | 24627 | Нефть,хий,нефтийн бүтээгдэхүүн |
| 15."Юнайтед технолоджиз" (Хартфорд,Коннектикут) | 17170 | 11928 | Нисдэгтэрэг, пуужин,онгоцны хөдөлгүүр,лифт, агааржуулагч |
| 16."Оксидентл петролеум" (Лос-Анжелес,Калифорни) | 17096 | 16739 | Нефть,хүнс, агрохими, нефтийн бүтээгдэхүүн |
| 17."Проектор энд Гамбл" (Цинциннати,Огайо) | 17000 | 13715 | Угаагч бодисууд, гоо засмын бараа |
| 18."Атлантик ричфилд" (Лос-Анжелес,Калифорни) | 16281 | 22669 | Нефтийн бүтээгдэхүүн |
| 19."Ар-Джей-Ар"Набиско (Атлант,Джорджия) | 15868 | 16861 | Тамхи.хүнсний бүтээгдэхүүн |
| 20."Боинг" (Сиэтл,Вашингтон) | 15355 | 12566 | Онгоц, пуужин |
| 21."Теннеко" (Хьюстон,Техас) | 15075 | 18503 | Нефтийн бүтээгдэхүүн, усан онгоц |
| 22."Би-Пи Америка" (Кливленд,Огайо) | 14611 | 23287 | Нефтийн бүтээгдэхүүн |
| 23."Ю-Эс-Экс" | 13898 | 19557 | Нефтийн бүтээгдэхүүн, |

| | | | |
|---|---|---|---|
| (Питтербург,Пенсильвани) | | | ган |
| 24."Доу кемикл" (Мидленд,Мичиган) | 13337 | 14356 | Химийн бүтээгдэхүүн |
| 25."Истмен Кодак" (Рочестер,Нью-Йорк) | 13305 | 14451 | Гэрэл зургийн тохеоремж |
| 26."Макдоннелл-Дуглас" (Сент-Луис,Миссури) | 13146 | 8535 | Онгоц, пуужин, нисдэг тэрэг |
| 27."Рокуэлл интернэшнл" (Питтербург,Пенсильвани) | 12123 | 8739 | Онгоц,пуужин,компьютер, аж үйлдвэрийн тоног тохеоремж |
| 28"Эллайд-Сигнал" (Морристван, Нью-Джирси) | 11597 | 10226 | Онгоц,пуужингийн тохееремж,автомашины сэлбэг,химийн бүтээгдэхүүн |
| 29."Пепсико" (Перчейз,Нью-Йорк) | 11500 | 9022 | Ундаа,түргэн үйлчилгээний кафены сүлжээ |
| 30."Локхид" (Калабасас,Калифорни) | 11370 | 6301 | Онгоц, пуужин |
| 31."Крафт" (Гленвью,Иллинойс) | 11010 | 5486 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 32."Филлипс петролеум" (Бартлесвилл,Оклахома) | 10721 | 12111 | Нефть,хий,Нефтийн бүтээгдэхүүн |
| 33."Вестингауз электрик" (Питтербург,Пенсильвани) | 10679 | 9953 | Электрон техник,цөмийн реактор, турбин |
| 34."Зирокс" (Стамфорд,Коннектикут) | 10320 | 11598 | Хувилагч,конторын тоног тохееремжүүд |
| 35."Гудьир тайр энд раббер" Акрон,Огайо) | 10123 | 8395 | Автомашины дугуйны хаймар бусад резин бүтээгдэхүүн |
| 36."Юнисиз" (Блу-Белл,Пенсильвани) | 9712 | 9958 | Компьютер,конторын тоног тохееремж |
| 37."Миннесота майнинг" энд маньюфекчуринг" (Сент-Пол,Миннесота) | 9429 | 8031 | Наалдамтгай лент,химийн бараа,эмнэлэг,эрдэм шинжилгээний тохееремж |

| | | | |
|---|---|---|---|
| 38."Диджитл Экуип-мент" (Мейнорд,Массачу-сетс) | 9389 | 8407 | Компьютер |
| 39."Дженерал Дайнэ-микс" (Сент-Луис,Миссури) | 9344 | 5031 | Онгоц,пуужин,усан онгоц |
| 40."Сара-Ли" (Чикаго,Иллинойс) | 9154 | 4191 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 41."Конагра" (Омаха,Небраска) | 9001 | 2482 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 42."Беатрис" (Чикаго,Иллинойс) | 8926 | 7903 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 43."Сан" (Раднор,Пенсиль-вани) | 8691 | 12580 | Нефть,хий,нефтийн бү-тээгдэхүүн |
| 44."Джорджиа-Паси-фик" (Атлант,Джоржи) | 8603 | 5870 | Цаас, модон эдлэл |
| 45."Интернэшнл теле-фон энд телеграф" (ИТТ) (Нью-йорк,Нью-Йорк) | 8551 | 13354 | Электрон техник |
| 46."Юнокал" (Лос-Анжелес,Кали- | 8466 | 10062 | Нефть,хий,нефтийн бүтээгдэхүүн форни) |
| 47."Анхейзер-Буш" (Сент-Луис,Миссури) | 8258 | 6491 | Шар айраг |
| 48."Катерпиллер" (Пиори,Иллинойс) | 8180 | 6806 | Хөдөө аж ахуйн маши-нууд |
| 49."Хьюлетт-Паккард" (Пало-Альто,Калифорни) | 8090 | 8133 | Компьютер |
| 50."Джонсон энд Джон-сон" (Нью-Брансуик,Нью- Джерси) | 8019 | 6546 | Эмийн бүтээгдэхүүн |

| | | | |
|---|---|---|---|
| 51."Алюминиум компани" оф Амэрика" (АЛКОА) (Питтербург,Пенсильвани) | 7767 | 9901 | Хөнгөн цагаан |
| 52."Интернэшнл пейпер" (Перчейз,Нью-Йорк) | 7763 | 8710 | Цаас, модон эдлэл |
| 53."Рейтион" (Лексингтон,Массачусетс) | 7659 | 4062 | Электрон, техник |
| 54."Кока-кола" (Атлант,Джорджи) | 7658 | 8355 | Ундаа, үйлдвэрлэл |
| 55."Монсанто" (Сент-Луис,С"Миссури) | 7693 | 8455 | Агрохимийн бүтээгдэхүүн |
| 56."Эл-Ти-Ви" (Даллас,Техас) | 7581 | 5706 | Ган,пүүжин,электрон техник |
| 57."Коастл" (Хьюстон,Техас) | 7413 | 7989 | Нефть,хий,нефтийн бүтээгдэхүүн |
| 58."Уэйэрхоузер" (Такома,Вашингтон) | 6989 | 7201 | Цаас, модон эдлэл |
| 59."Юнион карбайд" (Данбери,Коннектикут) | 6914 | 7892 | Химийн бүтээгдэхүүн |
| 60."Эшленд ойл" (Расселл,Кентукки) | 6870 | 4058 | Нефть, хий,нефтийн бүтээгдэхүүн |
| 61."Ти-Ар-Дабл-ю" (ТРВ) (Кливленд,Огайо) | 6821 | 4377 | Электрон,техник пүүжин, онгоц,автомашин, аж үйлдвэрийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл |
| 62."Моторола" (Шомберг,Иллинойс) | 6707 | 5321 | Электрон техник,пүүжин |
| 63."Ханиуэлл" (Миннеаполис,Миннесота) | 6679 | 5205 | Электрон техник |
| 64."Борден" (Нью-Йорк,Нью-Йорк) | 6514 | 4157 | Хүнсний бүтээгдэхүүн |

| | | | |
|---|---|---|---|
| 65."Америкэн брэндс" (Олд-Гринуич,Коннектикут) | 6323 | 7343 | Тамхи |
| 66."Бакстер трявенол лабо ретриз" (Дирфилд,Иллинойс) | 6223 | 7638 | Эм |
| 67."Эмерсон электрик" (Сент-Луис,Миссури) | 6170 | 4867 | Электрон техник |
| 68."Пиллсбери" (Миннеаполис,Миннесота) | 6127 | 3853 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 69."Нортроп" (Лос-Анжелес,Калифорни) | 6052 | 3123 | Онгоц, пуужин |
| 70."Ралстон пурина" (Сент-Луис,Миссури) | 5863 | 3863 | Малын тэжээлийн бүтээгдэхүүн |
| 71."Арчер"Дэниелс-Мидленд" (Декейтер,Иллинойс) | 5774 | 3862 | Малын тэжээлийн бүтээгдэхүүн |
| 72."Текстрон" (Правиденс,Род-Айленд) | 5661 | 5343 | Нисдэг тэрэг,аж үйлдвэрийн тоног төхөөрөмж |
| 73."Колгейт палмолив" (Нью-Йорк,Нью-Йорк) | 5647 | 3227 | Угаагч бодисууд |
| 74."Эн-Си-Ар" (НСР) (Дейтон,Огайо) | 5640 | 4187 | Компьютер, конторын төхөөрөмж |
| 75."Тексас инструменте" (Даллас,Техас) | 5594 | 4256 | Электрон техник |
| 76."Бристол-Майерс" (Нью-Йорк,Нью-Йорк) | 5401 | 4732 | Эм |
| 77."Дженерал миллс" (Миннеаполис, Миннесота) | 5208 | 2280 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 78."Пи-Пи-Джи-индастриз" (Питтербург,Пенсильвани) | 5182 | 4987 | Барилгын материал |

| | | | |
|---|---|---|---|
| 79."Мартин-Мариетта" (Бетесда,Мэриленд) | 5165 | 2794 | Онгоц, пуужин |
| 80."Мерк" (Роуэй.Нью-Джерси) | 5061 | 5680 | Эм |
| 81."Грейс" (Нью-Йорк,Нью-Йорк) | 5046 | 4473 | Химийн бүтээгдэхүүн |
| 82. "Америкэн хоум продактс" (Нью-Йорк,Нью-Йорк) | 5028 | 4608 | Эм |
| 83.Пфайзер" (Нью-Йорк,Нью-Йорк) | 4919 | 6922 | Эм |
| 84."Си-Пи-Си интернэшнл" (Инглвуд-Клиффс, Нью-Джерси) | 4903 | 3260 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 85."Кимберли Кларк" (Даллас,Техас) | 4884 | 3885 | Цаас,модон бүтээгдэхүүн |
| 86."Норт америкэн филипс" (Нью-Йорк,Нью-Йорк) | 4846 | 3102 | Электрон техник |
| 87."Амерада Хесс" (Нью-Йорк,Нью-Йорк) | 4784 | 5304 | Нефть,хий,нефтийн бүтээгдэхүүн |
| 88."Хейнц" (Питтербург,Пенсильвани) | 4639 | 3364 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 89."Бетлехам стил" (Бетлехем,Пенсильвани) | 4620 | 4774 | Ган |
| 90."Чемпион интернэшнл" (Стамфорд,Коннектикут) | 4614 | 6103 | Цаас, модон бүтээгдэхүүн |
| 91."Хёхет Селанис" (Сомервилл, Нью-Джерси) | 4596 | 5328 | Химийн бүтээгдэхүүн |
| 92."Ай-Си индастриз" | 4581 | 4871 | Хүнсний бүтээгдэхүүн,авто- |

| | | | |
|---|---|---|---|
| (Чикаго,Иллинойс) | | | машины сэлбэг,аж үйлдвэрийн тоног төхөөрөмж |
| 93."Куайкер оутс" (Чикаго, Иллинойс) | 4538 | 3250 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 94."Кэмпбелл суп" (Камден,Нью-Джерси) | 4490 | 3090 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 95. "Джеймс ривер корпорейшн оф Вирджиния" (Ричмонд,Вирджиния) | 4479 | 4210 | Цаас, модон эдлэл |
| 96."Литтон индестриз" " (Беверли"Хилс,Калифорни) | 4419 | 4880 | Электрон техник |
| 97."Эббот лаборэтриз" (Норт-Чикаго,Иллинойс) | 4387 | 4385 | Эм |
| 98."Трайангл индестриз" (Нью-Йорк,Нью-Йорк) | 4336 | 3771 | Металл бүтээгдэхүүн |
| 99."Би-Эй-Эс-Эф" (БАСФ) (Парсиппани,Нью-Джерси) | 4338 | 2557 | Химийн бүтээгдэхүүн |
| 100."Смиклайн Бекман" (Филадельфия,Пенсильвани) | 4328 | 4446 | Эм |
| 101."Рейнолдс металс" (Ричмонд,Вирджиния) | 4283 | 4314 | Хөнгөн цагаан |
| 102."Мид" (Дейтон,Огайо) | 4208 | 2917 | Цаас, модон эдлэл |
| 103."Байер Ю-Эс-Эй" (Питтербург,Пенсильвани) | 4198 | 3127 | Химийн бүтээгдэхүүн |
| 104. "Тайм" (Нью-Йорк,Нью-Йорк) | 4193 | 4423 | Ном,сэтгүүл |
| 105."Уэрпул" (Бентон-Харбор, Мичиган) | 4179 | 2417 | Гэр ахуйн цахилгаан бараа |

| | | | |
|---|---|---|---|
| 106."Америкэн сайанамд" (Уэйн,Нью-джерси) | 4166 | 4129 | Химийн бүтээгдэхүүн |
| 107."Дана" (Толидо,Огайо) | 4142 | 2802 | Автомашины сэлбэг |
| 108."Дир" (Молин,Иллинойс) | 4134 | 4759 | Хөдөө аж ахуйн машинууд, экскаватор |
| 109."Скотт пейпер" (Филадельфи,Пенсильвани) | 4122 | 4480 | Цаас, модон эдлэл |
| 110."Итон" (Кливленд,Огайо) | 4053 | 3026 | Электрон техник, машины сэлбэг |
| 111."Эли Лилли" (Индианаполис, Индиана) | 4049 | 5254 | Эм |
| 112."Файрстоун тайр энд раббер" (Чикаго,Иллинойс) | 3867 | 2921 | Машины дугуйны хаймар, бусад резинэн эдлэл |
| 113."Бойсе кэскейд" (Бойсе,Айдахо) | 3820 | 3374 | Цаасан, модон эдлэл |
| 114."Келлог" (Батл-Крик,Мичиган) | 3793 | 2681 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 115."Хэнсон индастриз Норт Америка" (Айзелин,Нью-Джерси) | 3789 | 2933 | Химийн бүтээгдэхүүн |
| 116."Оуэнс-Иллинойс" (Толидо,Огайо) | 3714 | - | Барилгын материал |
| 117."Свифт индепендент" (Даллас,Техас) | 3692 | 362 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 118."Купер индастриз" (Хьюстон,Техас) | 3585 | 3800 | Электрон техник |
| 119."Борг-Уорнер" (Чикаго,Иллинойс) | 3553 | 4964 | Химийн бүтээгдэхүүн |
| 120."Навистар Интернэшнл" (Чикаго,Иллинойс) | 3529 | 1902 | Ачааны машин |

| | | | |
|---|---|---|---|
| 121."Уорнер-ламберт" (Моррис-Плейнс,Нью-Джерси) | 3484 | 2475 | Эм |
| 122."Инленд стил индастриз" (Чикаго,Иллинойс) | 3453 | 2651 | Ган |
| 123."Американ стандартд" (Нью-Йорк,Нью-Йорк) | 3438 | 2398 | Аж үйлдвэрийн тоног төхөөрөмж |
| 124."АМАКС" (Гринуич,Коннектикут) | 3434 | 3969 | Молибден |
| 125."Контрол дейта" (Миннеаполис,Миннесота) | 3366 | 2638 | Компьютер, конторын тоноглол |
| 126."Кока-кола энтерпрайсиз" (Атланта,Жоржия) | 3329 | 4250 | Төрөл бүрийн ундаа |
| 127."Грумман" (Бетпейдж,Нью-Йорк) | 3325 | 2254 | Онгоц, пуужин |
| 128."Комбасчн инжиниринг" (Стамфорд,Коннектикут) | 3301 | 2703 | Электрон техник |
| 129."Эвон продактс" (Нью-Йорк,Нью-Йорк) | 3292 | 2559 | Угаагч бодисууд,гоо заслын бараа |
| 130."Берлингтон Холдингс" (Нью-Йорк,Нью-Йорк) | 3279 | 3491 | Сүлжмэл эдлэл |
| 131."Юнайтед брэндс" (Цинциннати,Огайо) | 3268 | 1116 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 132."Эгуэй" (Ди-Уитт,Нью-Йорк) | 3264 | 1421 | Нефтийн бүтээгдэхүүн |
| 133."Стоун контейнерс" (Чикаго, Иллинойс) | 3232 | 2286 | Цаасан бүтээгдэхүүн |
| 134."Теледайн" (Лос-Анжелес,Калифорни) | 3216 | 3125 | Электрон техник,хөдөлгүүр, металл,нефтийн олборлолт, хатгуулалт |

| | | | |
|---|---|---|---|
| 135."Жиллетт" (Бостон,Массачусетс) | 3166 | 2731 | Сахлын хэрэгсэл |
| 136."Таймс миррор" (Лос-Анжелес,Калифорни) | 3154 | 3122 | Сонин |
| 137."Эф-Эм-Си" (ФМС) (Чикаго,Иллинойс) | 3139 | 2595 | Химийн бүтээгдэхүүн,аж үйлдвэр,хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж,цэргийн тээврийн хэрэгсэл |
| 138."Дрессер индастриз" (Даллас,Техас) | 3119 | 2882 | Нефть олборлолтын тоног төхөөрөмж |
| 139."Женкорп" Фэрлон,Огайо) | 3101 | 1108 | Машины дугуйны хаймар, бусад резинэн эдлэлүүд |
| 140."Брансуик" (Скоки,Иллинойс) | 3086 | 1896 | Аж үйлдвэрийн тоног төхөөрөмж |
| 141."Ганнет" (Арлингтон,Вирджини) | 3079 | 3510 | Сонин |
| 142."Ю-Эс-Джи" (Чикаго,Иллинойс) | 3046 | 2094 | Барилгын материал |
| 143."Армко" (Парсиппани,Нью-Джерси) | 2927 | 2786 | Ган |
| 144."Оуэнс-Корнинг-Фиберглас" (Толидо,Огайо) | 2891 | 1590 | Барилгын материал |
| 145."Ливер бразерс" (Нью-Йорк,Нью-Йорк) | 2856 | 1011 | Угаагч бодисууд |
| 146. "Уонг лаборэтриз" (Лоуэлл,Массачусетс) | 2836 | 2812 | Компьютер |
| 147."Фруэхауф" (Дэтройт,Мичиган) | 2784 | 1727 | Ачааны машин |
| 148."Кэммикс әнджин" (Колумбус,Индиана) | 2767 | 2019 | Автомашины хөдөлгүүр |
| 149."Шеринг*-Плау" (Мэдисон-Нью-Джерси) | 2839 | 3179 | Эм |

| | | | |
|---|---|---|---|
| 150."Геркулес" (Уилмингтон,Делавэр) | 2693 | 3492 | Химийн бүтээгдэхүүн |
| 151."Джонсон контролс" (Милуокин,Висконсин) | 2676 | 1739 | Электрон техник |
| 152."Эппл компьютер" (Капертино,Калифорни) | 2661 | 1477 | Компьютер |
| 153."Ингерсолл-Рэнд" (Вудклифф-Лейк, Нью-Джерси) | 2647 | 2248 | Аж үйлдвэрийн тоног төхөөрөмж |
| 154."Куантум кемикл" (Нью-Йорк,Нью-йорк) | 2642 | 2581 | Химийн бүтээгдэхүүн |
| 155."Интерко" (Сент-Луис,Миссури) | 2631 | 1720 | Хувцас |
| 156."Керр-Макги" (Оклахома-Сити, Оклахома) | 2608 | 3071 | Нефтийн бүтээгдэхүүн |
| 157."Грейт нозерн Некуза" (Стамфорд,Коннектикут) | 2589 | 3538 | Цаас, модон эдлэл |
| 158."Фармленд индастриз" (Канзас-Сити,Миссури) | 2580 | 1087 | Нефтийн бүтээгдэхүүн |
| 159."Ви-Эф" (ВФ) (Вайомиссинг,Пенсильвани) | 2573 | 1925 | Хувцас |
| 160."Апджон" (Каламазу,Мичиган) | 2521 | 3043 | Эм |
| 161."Америкэн петрофина" (Даллас,Техас) | 2484 | 1835 | Нефтийн бүтээгдэхүүн |
| 162"Доннэли энд санс" (Чикаго,Иллинойс) | 2482 | 2086 | Ном, сэтгүүлийн хэвлэлийн ажил |
| 163."Энгелхард" (Эдисон,Нью-Джерси) | 2479 | 1216 | Химийн бүтээгдэхүүн |

| | | | |
|---|---|---|---|
| 164."Эмхарт" (Фармингтон,Коннектикут) | 2454 | 2029 | Металл эдлэл (багаж хэрэгсэл,цосж гэх мэт) |
| 165."Херши фудс" (Херши, Пенсильвани) | 2433 | 1645 | Хүнсний бүтэгдэхүүн |
| 166."Паккар" (Белвью, Вашингтон) | 2423 | 1300 | Ачааны машин |
| 167"Ревлон груп" (Нью-Йорк,Нью-Йорк) | 2398 | - | Гоо зүй, бараа,угаагч , бодисууд |
| 168."Джим Уолтер" (Тампа,Флорида) | 2386 | 2931 | Барилгын материал |
| 169."Армстронг уорлд индастриз" (Ланкастер,Пенсильвани) | 2365 | 1602 | Хивс,мебель,барилгын гялгар хавтан |
| 170."Зенит электроникс" (Гленвью,Иллинойс) | 2362 | 1373 | Телевизор,гэр ахуйн цахилгаан хэрэглэл |
| 171."Эй-Эм-Пи" (АМП) (Гаррисберг,Пенсильвани) | 2317 | 2982 | Электрон техник |
| 172."Хормел" (Остин,Миннесота) | 2314 | 698 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 173. "Юнион кэмп" (Уэйн,Нью-Джерси) | 2307 | 2896 | Цаас, модон эдлэл |
| 174."Стерлинг драгу" (Нью-Йорк.Нью-Йорк) | 2300 | - | Эм |
| 175."Питни-Боуэ" (Стамфорд,Коннектикут) | 2250 | 2431 | Конторын тоног төхөөрөмж |
| 176."Кайзертек" (Окленд,Калифорни) | 2226 | 2591 | Хөнгөн цагаан |
| 177."Ром энд Хаас" (Филадельфия,Пенсильвани) | 2203 | 1954 | Химийн бүтээгдэхүүн |
| 178."Примарк" | 2197 | 1585 | Сав суулга,хүнсний зүйл |

| | | | |
|---|---|---|---|
| (Дирфилд,Иллинойс) | | | үйлдвэрлэх,хадгалах зориулалтын чингэлгүүд |
| 179."Лэнд О лейкс" (Арден-Хилс,Миннесота) | 2188 | 688 | Хүнсний бүтээгдэхүүн |
| 180."Гудрич" (Акрон,Огайо) | 2168 | 1938 | Химийн бүтээгдэхүүн |
| 181."Трибьюн" (Чикаго,Иллинойс) | 2160 | 2758 | Сонин |
| 182."Скуибб" (Принстон,Нью-Джерси) | 2156 | 2782 | Эм |
| 183."Эйр продактс энд кемиклс" (Аллентаун,Пенсильвани) | 2140 | 2701 | Химийн бүтээгдэхүүн |
| 184."Юниверсл" (Ричмонд,Вирджиния) | 2103 | 943 | Тамхин бүтээгдэхүүн |
| 185."Шервин-Уильямс" (Кливленд,Огайо) | 2094 | 1140 | Химийн бүтээгдэхүүн, байшингийн төрөл бүрийн хавтангууд |
| 186."Корнинг гласс уоркс" (Корнинг, Нью-Йорк) | 2083 | 2658 | Шилэн эдлэлүүд |
| 187."Харрис" (Мелборн,Флорида) | 2079 | 1796 | Электрон техник |
| 188."Найт-Риддер" (Майами,Флорида) | 2072 | 1985 | Сонин |
| 189."Уэст-Пойнт пепперел" (Уэст-Пойнт,Джордж) | 2067 | 1563 | Сүлжмэл эдлэл |
| 190."Мэнвилл" (Денвер,Колорадо) | 2063 | 2715 | Барилгын материал |
| 191."Нолл интернэшнл холдингс" (Нью-Йорк,Нью-Йорк) | 2036 | 1796 | Резинэн эдлэл |
| 192."Сигрэм энд санс" (Нью-Йорк,Нью-Йорк) | 2028 | 6301 | Согтууруулах ундаа |

| | | | |
|---|---|---|---|
| 193."Маско" (Тейлор,Мичиган) | 2023 | 2850 | Усны хоолой,бусад сантехникийн хэрэглэлүүд |
| 194."Мортон-Тиокол" (Чикаго,Иллинойс) | 1987 | 1666 | Химийн бүтээгдэхүүн, сансрын хөлгийн сэлбэг |
| 195."Блэк энд Декер" (Тоусон,Мэриленд) | 1934 | 1668 | Аж үйлдвэрийн тоног төхөөрөмж,багаж хэрэгсэл |
| 196."Олин" (Стамфорд,Коннектикут) | 1930 | 1685 | Химийн бүтээгдэхүүн |
| 197."Бейкер-Хьюз" (Хьюстон,Техас) | 1923 | 2188 | Нефть олборлолтын тоног төхөөрөмж |
| 198."Луизиана-Пасифик" (Портленд,Орегон) | 1921 | 1971 | Цаас, модон эдлэл |
| 199."Мейтаг" (Ньютон,Айова) | 1908 | 854 | Гэр ахуйн цахилгаан бараа |
| 200."Интел" (Санта-Клара,Калифорни) | 1907 | 2597 | Электрон техник |